



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2019.11.14 № 113975
танай _____-ны № _____-т


**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ц.МӨНХ-ОРГИЛ ТАНАА**

Таны 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 24
тоот асуулга тавих тухай албан бичигтэй танилцлаа.
Жолоочийн даатгалын тухай хуулийн
хэрэгжилттэй холбоотой асуудлаар ирүүлсэн таны
асуулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 5 хуудас.

Хүндэтгэсэн,


ДАРГА



СЛАВААСҮРЭН

001375

Санхүүгийн зохицуулах хорооны
2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн
1/397.5 тоот албан бичгийн хавсралт



ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ АСУУЛГЫН ХАРИУ

1. Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2012 он нь Монгол улсын даатгалын салбарт огцом өсөлт бий болсон жилүүдийн эхлэл байсан бөгөөд тухайлбал тус онд даатгалын салбарын нийт хураамж болон нөхөн төлбөрийн хэмжээ тус тус 1.6 дахин, жолоочийн хариуцлагын даатгалын гэрээний тоо 14 дахин буюу 26,677-оос 373,480 болтол нэмэгдсэн юм. 2012 оноос 2018 оныг дуустал хугацаанд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал (цаашид “ЖХАЖД” гэх)-ын хүрээнд нийт 3,412,450 даатгалын гэрээ байгуулагдаж, 165.7 тэрбум төгрөгийн даатгалын нийт хураамж төвлөрч үүнээс нийт давхардсан тоогоор 178,865 даатгуулагчид 89.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгогдсон бөгөөд тус даатгал нь өнгөрсөн 7 жилийн дунджаар салбарын даатгалын нийт хураамжийн 20 хувь, нийт нөхөн төлбөрийн 36.4 хувийг дангаар бүрдүүлдэг чухал ач холбогдол бүхий даатгал юм. ЖХАЖД-ийн 2012-2018 оны статистик мэдээллийг дараах хүснэгтээр харуулав.

Он	ЖХАЖД-ын хураамж	ЖХАЖД-ын нөхөн төлбөр	ЖХАЖД-ын гэрээний тоо	ЖХАЖД-ын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо
2012	16,298,075,693.9	4,792,365,946.4	373,480	9,521
2013	15,154,923,378.7	10,643,661,299.3	357,654	19,000
2014	20,088,798,626.1	12,373,224,877.7	418,861	28,034
2015	22,927,430,530.5	14,698,934,723.6	444,317	33,269
2016	27,795,509,631.4	14,810,367,102.7	586,353	30,483
2017	30,445,439,946.5	15,507,437,334.5	543,274	28,782
2018	32,979,853,449.9	17,062,123,524.6	688,511	29,776

2. Жолоочийн даатгалын тухай хуулийн зорилт нь жолоочийг хариуцлагын албан журмын даатгалд хамруулах, зам, тээврийн ослын улмаас бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, хохирогчийн эрхийг хамгаалах юм. Энэхүү үндсэн зорилтыг бүрэн хэрэгжүүлэхийн тухайд даатгалын тохиолдлыг шалгах, даатгагч болон жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгохтой холбоотой хуулийн заалтуудад өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд үүний тулд даатгалын тохиолдлыг шуурхай шалгах, нөхөн төлбөр олгоход хохирогч, даатгуулагч нарт хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр даатгалын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй болгохтой холбоотой зохицуулалтыг сайжруулах хэрэгтэй юм. Тухайлбал, Жолоочийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан даатгалын тохиолдлыг шалгах, 25 дугаар зүйлд заасан шуурхай албатай холбоотой

заалтуудыг өөрчлөх, Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн даатгалын нөхөн төлбөрийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулах гэх мэт.

Мөн Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлийн 12^{1.1}-д заасан Албан журмын даатгагчдын холбооны статусыг тодорхой болгож, тухайн байгууллагын үйл ажиллагаанд нь хяналт тавих хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна. Тухайлбал, Албан журмын даатгагчдын холбоо нь ЖХАЖД-ын үйл ажиллагаанд хяналт тавих, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий мэдээллийн санг, даатгалд хамрагдаагүй эсхүл гэрээний хугацаа нь дууссан түүнчлэн даатгалын тохиолдол гаргаан жолооч зугтаасан болон даатгагч нь дампуурсан зэрэг тохиолдолд жолоочоос бусад этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилготой жолоочийн даатгалын санг тус тус хэрэгжүүлдэг. Иймд тус холбоо нь Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх, гишүүдийн уялдаа холбоог хангах, даатгуулагч, хохирогч нарт хүртээмжтэй, шуурхай даатгалын үйлчилгээ үзүүлэх зэрэг маш чухал үүрэгтэй байгууллага байх ёстой. Гэтэл өнөөдрийн байдлаар тус холбооны статус тодорхой бус, үйл ажиллагаанд нь хуулийн дагуу хяналт, шалгалт хийж холбогдох үүрэг хариуцлагыг шаардах эрх зүйн орчин сул байгаа тул Хорооноос баталсан зарим зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлдэггүй, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлдэггүйн улмаас үл ойлголцол бий болдог, гишүүдийнхээ уялдаа холбоог хангаж ажилладаггүйгээс Албан журмын даатгагчдын холбоо, даатгалын компаниуд, даатгалын зуучлагч компаниудын хамтын ажиллагаанд хүндрэл үүсэж, маргаан гардаг зэрэг нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буйг дурдах нь зүйтэй байна. Иймд Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийн хуралд Хорооноос оролцсон төлөөллүүд Албан журмын даатгагчдын холбооны статусыг тодорхой болгох талаар санал өгсөн.

3. Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 86/313 тоот хамтарсан тушаалаар Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Тус ажлын хэсэгт Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, даатгалын компаниуд, даатгалын мэргэжлийн холбоод болон Албан журмын даатгагчдын холбооны төлөөлөл багтсан бөгөөд нийт 4 удаагийн ажлын хэсгийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулаад байна.

4. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 211 дүгээр тогтоолоор “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг шинэчлэн баталж, Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Уг журмыг Хороо 2018 онд шинэчлэн батлахдаа Захиргааны ерөнхий хуулийн 59, 60 дугаар зүйлд нийцүүлэн Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт заасан буюу даатгалын хураамж тооцох зарим итгэлцүүрт өөрчлөлт орсон.

Энэхүү журмыг Санхүүгийн зохицуулах хороо 2011 онд анхлан боловсруулан баталж, 2018 онд шинэчлэн батлахдаа даатгуулагчийг урамшуулах буюу хураамж буурах, хариуцлагажуулах буюу хураамж өсөх зохицуулалтыг Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу журмаар зохицуулж байгаа болно.

Дээр дурдсан 2018 онд шинэчлэн баталсан журмын дагуу жолоочийн даатгалын хураамжийг тооцох итгэлцүүрт дараах өөрчлөлтүүд орсон болно:

- 1) Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-г заасан итгэлцүүрийг тооцохдоо зөвхөн даатгалын тохиолдлын тооноос хамааруулан тооцдог байсан бол даатгалын тохиолдлын тоо болон олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамааруулан тооцохоор өөрчилснөөр нэгдүгээрт тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлэх, хоёрдугаарт жолооч нарыг хариуцлагажуулах,

урамшуулах систем оновчтой хэрэгжих буюу даатгуулагч хэдэн удаа тохиолдол гаргасан, нийт хэдий хэмжээний нөхөн төлбөр авсан /өмнө нь 1 удаа 100 мян.төг эсвэл 1 сая.төг-ийн нөхөн төлбөр авсан даатгуулагчийн хураамж өсөх хариуцлага нь ижил байсан бол одоо энэ тохиолдолд ялгаатай тооцно/ гэдгээр нь ялгаатай тооцохоор зохицуулсан;

2) Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр заавал даатгуулахаар заасан бөгөөд тээврийн хэрэгслийн өмчлөгч нь хувь хүн эсвэл хуулийн этгээд байдаг. Өмнөх журмын зохицуулалтаар хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгалын хураамжийг тооцохдоо зарим итгэлцүүрийг тооцдоггүй байсан. Харин журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж батлан хүчин төгөлдөр мөрдүүлэхийн тулд хувь хүний болон хуулийн этгээдийн аль ч өмчлөлийн тээврийн хэрэгслийн ЖХАЖД-ын хураамжийг тооцохдоо Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасан итгэлцүүрийг бүрэн тооцох шаардлагатай байсан тул хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийн ЖХАЖД-ын хураамжийг тооцоход жолоочийн нас, тээврийн хэрэгсэл жолоодох туршлагаас хамаарах итгэлцүүрийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т нийцүүлэн нэмэлт оруулсан. Үүнтэй мөн адил дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн ЖХАЖД-ын хураамжийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т нийцүүлэн бүрэн тооцохоор зохицуулсан;

3) Орхон, Дархан-Уул аймгуудын газар нутгийн байршлаас хамаарах итгэлцүүрийг хөдөлгөөний нягтрал, даатгалын тохиолдлын давтамжаас хамаарч өөрчлөлт оруулсан бөгөөд нөгөө талдаа энэ 2 аймагтай даатгалын гэрээний тоо ойролцоо, нийт автомашины тоо өндөр байдаг буюу өмнөх итгэлцүүр нь ижил байсан Сэлэнгэ, Төв аймгуудын газар нутгийн байршлын итгэлцүүрийг буулгасан.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах”, 5.3-т “Автотээврийн тухай хуулийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.1-д ““жолооч” гэж автотээврийн хэрэгсэл болон мотоциклийг жолоодож яваа хүнийг”, 3.1.4-т ““даатгуулагч” гэж даатгагчтай даатгалын гэрээ байгуулж замын хөдөлгөөнд оролцох үедээ бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан этгээдийг” гэж, мөн тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “... хураамжийн хэмжээг дараах итгэлцүүрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцно” гээд 11.1.6-д “тээврийн хэрэгслийг ашиглах тоо” гэж тус тус заасан байдаг. Энэхүү хуулийн заалтуудыг үндэслэн тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцох жолооч бүр бусдын өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан байхаар даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн тоог зааж, нэр дурдах эсхүл тоог хязгаарлахгүй байх сонголттойгоор журмаар зохицуулсан.

Гэтэл 2012 оноос хойш хэрэгжиж байгаа энэхүү зохицуулалтыг Албан журмын даатгагчдын холбоо үгүйсгэж, даатгалын гэрээнд нэр зааж даатгуулж байсан жолооч нарыг даатгуулагч биш гэж үзэн одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, тогтоомжийг зөрчин жолоочийн даатгалын МИИС програмд 2019 оноос эхлэн өөрчлөлт оруулсан байна. Ингэхдээ даатгалын гэрээнд нэр дурдсан жолооч өмнөх жилүүдэд даатгуулан нөхөн төлбөр аваагүй,

итгэлцүүр нь буурсан байсан хэдий ч урд нь тээврийн хэрэгслийн өмчлөгчөөр даатгуулсан мэдээлэл байхгүй гэх шалтгаанаар өмнөх жилүүдэд нэр дурдсан жолоочоор даатгуулан хураамж нь буурсан түүхийг үл харгалзан тухайн итгэлцүүрийн үржвэрийг “1” гэж тооцож байна. Хэрэв жолооч тээврийн хэрэгслийн өмчлөгчөөр даатгуулсан түүх үүсэхгүй бол цаашид нөхөн төлбөр огт аваагүй байсан ч хураамж буурахгүй, харин даатгуулагч жолооч даатгалын тохиолдол гаргаж нөхөн төлбөр авсан бол хураамжийг өсгөж тооцохоор тохируулсан байна. Уг тохируулгаас хамаарч ЖХАЖД-ын хураамж нэмэгдэж даатгуулагч нарт дарамт үүсгэж байгаа бөгөөд Албан журмын даатгагчдын холбоо нь Хорооноос хураамжийг нэмсэн гэх тайлбарыг даатгуулагч нарт өгсөн талаар Хороонд хандсан гомдлуудад дурдаж байсан.

Хорооноос Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн журмыг шинэчлэн батлахдаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, даатгалын хураамжийг нэмэгдүүлэхгүй байх зарчим баримталсан бөгөөд тэр дундаа даатгуулагчийн дийлэнх буюу 80 гаруй хувийг эзэлдэг хувь хүний автотээврийн хэрэгслийн ЖХАЖД-ын хураамжийн дарамт үүсгэхгүй байхаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд эдгээр зохицуулалттай холбоотой үндэслэл тайлбар, танилцуулгыг хүргүүлснээр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн.

Мөн таны асуулгад “жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын өнгөрсөн 7 жилийн нийт хураамжийн 40 гаруй хувь нь даатгалын компаниудын ашиг болж үлдсэн тооцоо гарчээ” гэж дурдсан байх бөгөөд ямар үндэслэл тооцооллоор үүнийг даатгалын компаниудын ашиг гэж үзэж байгаа нь тодорхойгүй байна. Харин даатгалын хураамж нь даатгалын нөхөн төлбөр олгох, нөөц сан байгуулахад зарцуулагдаж, мөн гэрээ байгуулахтай холбоотой үндсэн үйл ажиллагааны зардал /үүнд даатгалын зуучлагч, төлөөлөгчийн шимтгэл/-ыг санхүүжүүлдгийг дурдах нь зүйтэй юм.

5. Жолоочийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Санхүүгийн зохицуулах хороо нь жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдын үйл ажиллагааны нэгдсэн уялдааг хангаж, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавина”, 26.3-д “Энэ хуулийн 5.1-5.3 дахь хэсгийн заалтын хэрэгжилтэд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын алба болон автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус хяналт тавина” гэж заасан байдаг. Иймд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэхэд Албан журмын даатгагчдын холбоо Даатгалын тухай хуулийн 12¹ дүгээр зүйлийн 12^{1.5}-д заасан үндсэн эрх, үүргийнхээ хүрээнд гишүүн даатгалын компаниудтайгаа нягт хамтарч ажиллах шаардлагатай юм. Энэ талаар Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 245 тоот тушаалаар Албан журмын даатгагчдын холбооны 2017 оны 2, 3, 4 дүгээр улирал, 2018 оны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтын тайланд “Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12^{1.5.2}-д “гишүүдийн ашиг сонирхлыг хамгаалах” гэж заасны дагуу гишүүдийн эрх ашгийг хамгаалж, нийт даатгагч, зуучлагч, хохирол үнэлэгч, даатгуулагч нарын уялдаа холбоог сайжруулахад анхаарч ажиллах”, “Жолоочийн даатгалын тухай хуулийн 23 дугаар хуулийн 23.1.4-т “зам, тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг санхүүжүүлэх” гэж заасны дагуу сургалт, сурталчилгааны чиглэлээр жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын ач холбогдлыг олон нийтэд таниулах, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд иргэд, даатгуулагч нарт зориулсан сургалтыг Улаанбаатар хот, хөдөө орон нутагт давтамжтайгаар зохион байгуулах, энэ чиглэлээр бусад байгууллага, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдтэй хамтарч ажиллах, сургалт, сурталчилгааны ажлынхаа үр дүнг дүгнэж ажиллах” гэсэн санал зөвлөмжүүдийг өгсөн.

6. Жолоочийн даатгалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Тээврийн хэрэгслийн өмчлөгч бүр жолоочийн даатгалд заавал хамрагдах”, 5.3-т “Автотээврийн тухай хуулийн 3.1.15-д заасан тээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч болон “С”, “D” ангиллын тээврийн хэрэгслээр замын хөдөлгөөнд оролцох жолооч нь тээврийн хэрэгслийн өмчлөгч эсэхээс үл хамааран жолоочийн даатгалд заавал даатгуулна” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.1-д “”жолооч” гэж автотээврийн хэрэгсэл болон мотоциклийг жолоодож яваа хүнийг”, 3.1.4-т “”даатгуулагч” гэж даатгагчтай даатгалын гэрээ байгуулж замын хөдөлгөөнд оролцох үелээ бусад этгээдийн өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан этгээдийг” гэж, мөн тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “... хураамжийн хэмжээг дараах итгэлцүүрээр нэмэгдүүлэх буюу хорогдуулан тооцно” гээд 11.1.6-д “тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тоо” гэж тус тус заасан байдаг. Энэхүү хуулийн заалтуудыг үндэслэн тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцох жолооч бүр бусдын өмнө хүлээх хариуцлагаа даатгуулсан байхаар даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн тоог зааж, нэр дурдах эсхүл тоог хязгаарлахгүй байх сонголттойгоор журмаар зохицуулсан.

7. Жолоочийн даатгалын сан нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасан эх үүсвэрүүдээс бүрдэхээр заасан бөгөөд өмнөх онуудын бүрдүүлэлт болон энэ сангийн хуримтлагдсан үлдэгдэл (2018 оны жилийн эцсийн байдлаар 19.4 тэрбум төгрөгт хүрсэн)-ээс үзэхэд уг хуулийн 23 дугаар зүйлд заасан зарцуулалт (сүүлийн 3 жилийн дунджаар жилд 1.3 тэрбум төгрөг зарцуулдаг)-ыг санхүүжүүлэхэд хангалтай байгаа юм. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тусгагдсанаар Жолоочийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулж жолоочийн даатгалын сангийн зарим эх үүсвэрүүд буюу тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, 22.1.4 дэх заалтуудыг хассан.

8. УИХ-аас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.18 дахь хэсэгт зааснаар 2017 оны 7 дугаар сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 11.15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэл болгон Жолоочийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасныг зөрчсөн үйлдэлд нийт 3.0 сая төгрөгийн торгууль ноогдуулж төлүүлсэн байна.